

ЖҮЖГИЙН ОРЧУУЛГААР Э.ОЮУНЫ ХУРИМТЛУУЛСАН ЗАРИМ ТУРШЛАГА

Ц.Магсар¹⁹

Товч утга: Зохиолч, найруулагч, урлаг судлаач, орчуулагч Э.Оюуны мэндэлсний 100 жилийн ойд зориулсан “Жүжгийн орчуулгаар Э.Оюуны хуримтлуулсан зарим туршилага” сэдэвт энэхүү өгүүлэлд жүжгийн эх дэх үндэсний болон үндэсний соёлын ул мөр бүхий үг утгасыг хөрвүүлэхдээ орчуулагчийн илүү давамгай хэрэглэсэн чөлөөтэй бүтээлч орчуулгын арга барилыг хэл шинжлэлийн үүднээс нэгтгэн тайлбарлажээ. Зохиогчийн үзэж байгаагаар энэхүү арга барил нь хэлээр илэрхийлсэн харь соёлын зүйлсийг монгол үзэгчдэд хялбар дөт дамжуулах гэсэн орчуулагчийн зорилгоос үүдэлтэй байна. Судалгааны объект нь Н.В.Гоголийн “Байцаагч түшмэл”, У.Шекспирийн “Лир ван”, А.Н.Арбузовын “Эрхүүгийн түүх” зэрэг жүжгийн зохиолын орчуулга юм.

Түлхүүр үг: жүжгийн зохиолын орчуулга, бүтээлч хандлага, соёлын ялгаа ба нийтлэг чанар

Жүжгийг ихэнх тохиолдолд тайзан дээр тавих зорилгоор, заримдаа мөн унших зорилгоор орчуулдаг байна. Германы судлаач Б.Шульц жүжгийн зохиолыг тайзан дээр тавих зорилгоор орчуулах нь нийтлэх хийгээд унших зорилгоор орчуулахаас эрс ялгаатай гэдгийг онцолжээ [8]. Тайзан дээр тавьж, үзэгчдэд сонсгох зорилго бүхий орчуулга нь орчуулгын ихээхэн өвөрмөц нэгэн хэлбэр юм. Учир нь аливаа жүжгийг хичнээн сайн орчуулсан бай, тайзан дээр тавихад тухайн найруулагчийн хүсэл зоригоос хамааран асуудал үүсэх нигууртай. Иймд орчуулга нийцгүй байх аваас найруулагч уг жүжгийн өөр шинэ орчуулга захиалах явдал цөөнгүй байх аж. Жүжгийг тайзан дээр тавихын тулд ажиллаж буй орчуулагч нь зохиолын гоо зүй, театрын гоо зүйг давхар бодолцох хэрэгтэй болдог. Үүгээрээ жүжгийн орчуулга уран зохиолын орчуулга дотроо ихээхэн онцлог төрөл болно. Өөрөөр хэлбэл жүжгийн орчуулга хэмээх бие даасан онол, практик байж болно гэсэн үг юм. “Жүжгийн зохиолыг партитура хэмээн үзэж театрын болон тайзны нөхцөл байдлыг ойлгож мэдрээд хийсэн орчуулга нүдэнд харагдахуйц болох ёстой гэдэг бол туйлын өвөрмөц шаардлага бөгөөд энэ нь хүүрнэл зохиол, яруу найргийг орчуулдаг зорилтуудтай огтхон ч уялдахгүй” гэж австрийн судлаач К.Беднарц энэ төрлийн орчуулгын шалгуурыг тодорхойлсон байна [4, 19].

Орчин үеийн монголын урлаг соёлын ид өрнөл хөгжлийн үед орчуулгын энэхүү ярвигтай төрөл зүйлээр анхлан дагнаж ажилласан хүн бол Эрдэнэбатын Оюун юм. Э.Оюун тайзан дээр тавих зорилгоор нийт дөчөөд жүжиг орчуулсан бөгөөд түүнээс арваадыг нь өөрөө буюу бусадтай хамтран найруулж тавьсан байна [1, 359, 360]. Тэрээр монголын үзэгчдийг Шекспир, Лопе де Вега, Генрик Ибсен, Бертольд Брехт, Шиллер, Войнич, Гоголь, Шолохов нарын дэлхийн

¹⁹ МУБИС, НХУС-ийн профессор, доктор

сонгодгуудтай танилцуулсан гавьяатай. Бид энэхүү өгүүлэлд орчин үеийн монголын уран зохиолд жүжгийн зохиолын орчуулгаар шан таталцсан, нэрт соён гэгээрүүлэгч Э.Оюуны зарим нэг туршлагыг хэл шинжлэлийн үүднээс ангилан тайлбарлах зорилго тавив.

Дээр дурдсан онцлог ёсоор жүжгийн зохиолын орчуулга нь, тухайлбал хүүрнэл зохиолынхтой харьцуулбал эхэд баригдаж үг үсгээр хөөцөлдөхгүй, орчуулагчаас ихээхэн бүтээлч хандлага шаарддаг байна. Үүний цаана жүжигт гарч буй яриа буюу дискурс үзэгчдэд эргэлзээ төвөггүй шууд хүрэх тухай зарчим үйлчилнэ. Орчуулгын энэхүү зарчмыг Э.Оюун хэрхэн баримталдаг байсныг “Байцаагч түшмэл” жүжгийг орчуулсан жишээн дээр харж болно. Жишээ нь, “И больные не походили бы на кузнецов” гэснийг “Өвчтөнүүд чинь дархны газрын хүмүүс шиг харагдах бий дээ” гэх маягаар орчуулсангүй, “*Хөө шиг хар болсон цамцы нь одоо даруй соливол зохино*” [2, 9] гэжээ. “Черт побери, есть так хочется и в животе трескотня такая, как будто бы целый полк затрубил в трубы” гэснийг мөн “Чөтгөр ав, өлсөж байгаа гэдэг нь. Гэдсэн дотор гарч байгаа чимээ хороо цэрэг бүрээ үлээж байгаа юм шиг” гэж орчуулсан байж болох ч орчуулагч тэгсэнгүй, зохиолын үйл өрнөл, дүрийн төрх байдлыг тодруулан “*Золиг шиг юм байх гэж дээ. Гэдэс өлсөж, ходоод дуугарч, хоол нэхэхий нь хэлэх үү? Энэ муу эзний минь тэнэгийг хэлэх үү?*” [2, 22] гэжээ. Ингэж орчуулсан нь тайзан дээрх яриаг илүү ойлгомжтой, хялбар дөхөм болгож байна. Ийнхүү бүтээлчээр орчуулахдаа дүрийн зан чанарыг тодруулах, хошин найруулгын өнгө аясыг лавшруулах зорилго өвөрлөсөн нь орчуулагчаас илт харагдаж байна. “У вас там в передней ...сторожа завели домашних гусей с маленькими гусенками, которые так и шныряют под ногами” гэсэн өгүүлбэрийг “...танай галч нар тэр өрөөн дотроо галуу тэжээсэн байна. Ороход энд тэнд хөл доогуур гүйлдээд л *хүн тээглэж ойчмоор байх юм*” [2, 9] гэх буюу “Что, приехал? ревизор? с усами! с какими усами?” гэсэн өгүүлбэрийг “Байцаагч түшмэл ирсэн үү? Сахалтай юм уу? *Байцаагч түшмэл чинь ямар хүн юм бэ? Гоё юм уу? Цэвэрхэн юм уу?* [2, 21] гэх мэтээр хотын дарга болон эхнэрийнх нь зан чанарыг илүү тодорхой харуулах зорилгоор чимж хачирлаж орчуулсан байна. Бүтээлч орчуулгын иймэрхүү жишээг олон жүжгийн орчуулгаас ажиглаж болох бөгөөд Э.Оюуны баримталдаг нэг зарчим байжээ гэж хэлж болно.

Мөн бүтээлч орчуулгын хэлбэр гэж үзүүштэй өөр нэг зүйл бол мэдээллийн хувьд онц ач холбогдолгүй буюу үндэсний соёлд нийцгүй хэмээн үзсэн байж болзошгүй, зарим үг, өгүүлбэрийг орчуулалгүй орхисон байна. Жишээ нь, “Эрхүүд болсон явдал” жүжигт хаа холын Ижил мөрний тэндэх онцын холбогдолгүй нэгэн зүйл мэдээллээр санал солилцож буй “(Валя) А на Волге, говорят, какая-то дивчина всей сменой на шагающем командует... Думаешь, возможно? (Виктор) Вполне” гэсэн харилцан яриаг орчуулаагүй байна.

Шүлэглэсэн эх буюу “Лир ван”-гийн орчуулгад жүжигчний яриаг сонсголонтой, яруу сайхан болгохын тулд ихээхэн ур гаргаж харьцангуй чөлөөтэй орчуулсан жишээ баримт олныг ажиглаж болно. “Лир ван”-г Э.Оюун орос эхээс орчуулахдаа тухайн үед орос хэл дээр гараад байсан тав зургаан хувилбараас

хамгийн сайн орчуулгад тооцогддог Б.Пастернакийн хувилбарыг сонгон авсан нь талархууштай байна. Б.Пастернакийн баримталж байсан орчуулгын зарчим Э.Оюуныхтай нийцэж байгаа юм. Учир нь англи эхийг Б.Пастернак аль болох оросжуулах бодолтой хөрвүүлснээр “Орос Шекспир” хэмээх нэр томъёо хүртэл гаргасан бол Э.Оюун уг орчуулгын хэмжээ хэлбэрт баригдалгүй монгол төрхтэй болгохыг зорьсон нь илт байна.

“Я больше всех
Любил ее и думал дней остаток
Провести у ней. - Ступай! Прочь с глаз моих!” гэдгийг
“Өтөлсөн насныхаа сүүлчийг би
Отгон охиныхоо гар дээр барж
Эдлэх зовлон зүдгүүргүйгээр
Элгээ дэвтээж амаръя гэсэн юм
Их санасан газар есөн шөнө хоосон гэдэг энэ үү?” [7, 323]

гэж орчуулснаас үүнийг харж болно. Мөн англи эхэд тойруу утгаар хэлэгдсэн хэллэгийг орос эхэд тэр чигт нь хадгалан орчуулсан байсныг монголоор шууд утга бүхий өвөрмөц хэллэгээр орчуулсан сонин жишээ байна. Тухайлбал:

- Do:
Kill thy physician, and the fee bestow
Upon thy foul disease.
Убей врача, а плату за лечение
Отдай болезни.

гэж орос хэлэнд уг утгасыг хадгалан хөрвүүлснийг монгол хэлэнд мөнхүү ёсоор нь орчуулахад тийм ч ойлгомжтой бус болно. Иймд:

Үхэр унасан хүнд нохой өшөөтэй
Үнэн үг хэлсэн хүнд хүн өшөөтэй [7, 325]

хэмээн орчуулгадаа өвөрмөц хэллэг ашигласан нь сонсголонтой бөгөөд уран яруу болжээ.

Уран зохиолын, тэр тусмаа жүжгийн зохиолын орчуулгад соёл, сэтгэхүйн ялгааг гаргаж орчуулах нь уншигч, үзэгчид уг зохиолыг шимтэн хүлээн авах таатай нөхцөл боломжийг бүрдүүлдэг учраас зайлшгүй шаардлагатай боловч бас амаргүй зорилт юм. Театрт бүх үйл явдал үзэгчдийн нүдэн дээр барин тавин болж өнгөрнө. Энд бусад төрлийн зохиолын орчуулгын нэгэн адил үндэсний онцлог үгсийн тайлбар сэлт хийх, орчин нөхцөлийг харгалзахгүйгээр соёл ахуйн зүйлсийг бүдүүн баргаар орлуулах боломжгүй. Судлаачдын дунд жүжгийн зохиолын орчуулгад анхдагч эхийн үндэсний шинжийг хэр хэмжээгээр хадгалах тухайд “үзэгчдийн герменевтик чадвар” хэмээх нэр томъёог хэрэглэдэг байна (Патрис Пави). Энэ нь түүхэн тодорхой нөхцөлд, зохиолд өгүүлж буй ард түмний талаарх мэдлэг төсөөлөл ямаршуу түвшинд байгааг харгалзан хийж буй орчуулга дахь соёлын хувиргалын нэг хэмжигдэхүүн болох ойлголт бөгөөд улмаар тэр нь тухайн ард түмнүүдийн соёлын нийтлэг чанар ямар хэмжээнд байгааг харуулахуйц үр дагавартай байна. Энэ үүднээс үзвэл нэг үндэсний соёл нөгөө үндэсний дунд дэлгэрч танигдсан түүхийн өөр хугацаанд

ямарваа зохиолын орчуулгыг ч бас шинээр өөрчлөн хийх тухай яриа байж болно гэсэн үг юм. Тухайлбал, Э.Оюун “Байцаагч түшмэл”-ийг орчуулж байсан (1936 он) үед монгол үзэгчдийн тухайд оросын үндэсний онцлогтой мэдээллүүд харьцангуй бага дэлгэрсэн байсныг орчуулагч тооцсон гэдэг нь дамжиггүй. Ийм учраас “Каждое воскресенье бываю в церкви” гэдгийг “*Хишиг өдөр бүр сүмд очдог*” [2, 11], “Ах, батюшки!” гэсэн аялга үгийг “*Ай бурхан минь*” [2, 14], “Свидетель Аполлон” гэдгийг “*Тэнгэрийг барьж тангараглая!*” [7, 325], мөн “Да, Аполлон Свидетель, что напрасно ты клянешься” гэдгийг “*Тэргэл саран гэрч шүү Төөрөгдөж байна та!*” [7, 325] гэх мэтээр орчуулсан нь үүний нотолгоо. Энд зөвхөн “Аполлон” гэдэг үгийг “нарны бурхан”, “гэрэлтүүлэгч, гийгүүлэгч” гэсэн ерөнхий утгад нь дүйцүүлэн “*тэнгэр*”, “*тэргэл саран*” гэж өөр өөрөөр орчуулсан нь ажиглагдаж байна.

Сэтгэхүйн ялгааг гаргах зорилгоор монголчлон найруулж орчуулсныг авч үзвэл энэ нь жүжгийн зохиолын орчуулгын тухайд туйлын ач холбогдолтой байна. Соёлын ялгаа гаргасан орчуулгыг түүхийн тодорхой хугацааны дараа өөрчлөх шинэчлэх боломжтой байдаг бол сэтгэхүйн ялгааны тухайд үндэстнүүдийн мөн чанар, өөрөөр хэлбэл ярих сэтгэх ялгаа зөрөөнд холбогдолтой тул ийм боломж хомс юм. Жишээ нь, “Ну, в ином случае много ума хуже, чем бы его совсем не было” гэдгийг “*Заримдаа их ухаантай хүн тэнэг хүнээс дор байдаг юм*” [2, 11] гэж орчууллаа гэмээж нь монгол хэл сэтгэхүйд сая ойртож очно. Үүн лүгээ адил “Да сказать Держиморде, чтобы не слишком давал воли кулакам своим; он, для порядка, всем ставит фонари под глазами — и правому и виноватому” хэмээх өгүүлбэрийг “*Бас Держиморда цагдаа, хэрэг хийсэн хүнийг ч тэр, хийгээгүй хүнийг ч тэр зоддог гэм байгаа юм. Тэр зангаа одоо бага дээрээ татасхийх хэрэгтэй гэж хэлээрэй*” [2, 20] гэж эх хэлнийхээ сайхан найруулгаар орчуулснаас “не слишком давать воли кулакам” гэдгийг “*тэр зангаа бага дээр нь татасхийх хэрэгтэй*” гэсэн нь туйлын оновчтой монгол орчуулгын жишээ гэж үзэхээр байна. Энд онцлон тодотгох нэг зүйл бол “не слишком давать” гэдгийг “*татасхийх*” гэсэн нь тухайн үгийн хэлзүйн хэлбэр болоод утга аясыг тун мэдрэмжтэй оноож орчуулсан байдал харагдаж байгаа юм.

Э.Оюуны орчуулгыг ажиглахад жүжгийн зохиолын амин сүнс болсон тайзны ярианы онцлогт тааруулж орчуулсан нь олонтаа ажээ. Үүнийг үг хэллэгийг сонгохдоо ойлгомжтой бөгөөд тодорхой, аль болох ярианы хэл рүү ойртуулсан орчуулгыг голлон баримталж байснаас харж болно. Жишээ нь, “Дождь ведь” гэдгийг “*Усан бороо орж байна шүү дээ*” [5, 258], “- Говорят, через две недели Ангару перекрывать будем. – Конец!” хэмээх харилцан ярианы “конец” гэдгийг (- Хоёр долоо хоногийн дараа Ангарын усыг боож эхлэх гэнэ лээ.) – “*Дуусах нь тэр дээ*” [5, 259], “- Если бы он узнал... вот радовался бы. – Да” хэмээх харилцан ярианы “да” гэдгийг (- Тэр минь мэдсэн бол хичнээн их баярлахсан бэ) – “*Яриа юу байх вэ*” [5, 259] гэх мэтээр орчуулсан байна. Жүжгийн ярианд нэг жүжигчний үгийг нөгөө жүжигчнийхээр тасалдуулах тохиолдолд хэлэх гэсний цаад утга агуулгыг алдагдуулахгүй орчуулах аргууд байдгийн нэг жишээг Э.Оюун орчуулгадаа харуулсан байна. Тухайлбал, “...а то, признаюсь, я уж думал, что вы пришли с тем, чтобы меня...” гээд үг тасалдахад цаана нь

“намайг шоронд хийх” гэсэн үгийн утгын хүрээлэл тодорхой байсан тул “–Харин үнэнээ хэлэхэд таныг түрүүн орж ирэхэд энэ ч намайг *шор...*” [2, 30] хэмээн “шорон” гэсэн үгийг хагас цухуйлган орчуулсан байна.

Э.Оюуны орчуулгад цөөн ч гэсэн ажиглагдах нэг зүйл бол орчуулсан жүжгийн тайзан дээр амилуулах зорилгодоо хөтлөгдөн найруулагчид санаа өгөх ремарка буюу нэмэлт тайлбар зүүлт хийж байжээ. Жишээ нь, А.Арбузовын “Эрхүүд болсон явдал” жүжигт сэтгэлийн дотоод хямрал догдлолоо барьж ядан хэлж буй “Первая... Если бы он узнал... вот радовался бы” гэсэн жүжигчний хэлэх үгийг орчуулахдаа “Анхны минь цалин (*нүдэнд нь нулимс цийлгэнэнэ*). Тэр минь мэдсэн бол хичнээн их баярлахсан бэ. [5, 259]” гэж найруулагчид туслах тайлбар нэмжээ.

Уран зохиолын орчуулгад өвөрмөц хэллэгийн орчуулга анхаарал татсан чухал асуудал байдаг. Өвөрмөц хэллэгийг орчуулахдаа Э.Оюун мөн л жүжгийн яриа үзэгчдэд хүрэх талыг илүү бодолцсон нь харагдаж байна. Жишээ нь, орос хэлний “мотать себе на ус” хэмээх өвөрмөц хэллэгийг Чой. Лувсанжавын өвөрмөц хэллэгийн толь бичигт тайлбарлахдаа “санаандаа санаж шанаандаа зуух”, “цээжиндээ хадаж авах” [3, 322] гэх мэтээр монгол дүйцлүүдийг сонгож оруулсан байдаг. Жүжигт ийм байдлаар орчуулъя гэвэл яриандаа эвлэх авцалдах талаасаа нэг л таарамжгүй болж мэднэ. Иймд “Даром что далеко, а оно себе мотает на ус” гэсэн өгүүлбэрийг “Хол боловч бас л *чагнаж сэрэмжилж байгаа* шүү дээ” [2, 9] гэж шууд утгаар нь орчуулжээ. Дашрамд хэлэхэд өвөрмөц хэллэгийн орчуулга дүйцлээ олбол яруусалтай, эс олбол илүүц зүйл болдог учраас утга нийцээгүй хэллэг сонгосноос шууд утгаа барьж орчуулсан нь дээр гэдэг нь ойлгомжтой. Өвөрмөц хэллэгийн дүйцлийн тухайд гэвэл Э.Оюуны орчуулгад оновчгүй болсон зүйл ч мэр сэр байгааг тэмдэглэх нь зүйтэй. Жишээ нь, “Вот не было заботы, так подай!” гэдгийг “*Зовлон байдаггүй юмсан, одоо ч хэцүүдэж ээ*” [2, 7] (боломжит хувилбар нь “*Хийх юм олдохгүй байсан, гараад ирлээ*”), “Оба пальцем в небо попали” гэдгийг “*Хоёулаа онож дээ*” [2, 13] (боломжит хувилбар нь “*Үгээ олдог ч болоосой; Мөн яриваа, та хоёр*”), “Говорят, что я им солоно пришелся” гэдгийг “*Би эдэнд тохирохгүй байгаа бололтой юм*” [2, 13] (боломжит хувилбар нь “*Би тэдэнд гай болж байгаа юм байхаа*”) гэх мэтээр орчуулжээ.

Мөн уран зохиолд оноосон нэрийг ямар нэгэн үүргээр хэрэглэж, тэр нь цаанаа утга агуулсан байх аваас (Ч.Лодойдамбын “Малгаатай чоно” өгүүллэгийн Хэтрүүдорж, Аймар, Сүсэгжав лугаа адил) орчуулах нь зохимжтой. Тэр бүү хэл баатруудын нэрийг орчуулахгүй бол зохиолын уран санаа гүйцэд гарахааргүй, А.Чеховын “Лошадиная фамилия” (Адуу овогт) өгүүллэг мэтийн зохиол ч бий. Э.Оюуны орчуулсан жүжгийн зохиолын дотроос Н.В.Гоголийн “Байцаагч түшмэл” жүжиг ийм хэлбэрийн зохиолд хамаарна. Ер нь Гоголийн зохиолуудын баатрын нэрс үзэгч, уншигчийн сэтгэхүйд ямар нэгэн ассоциаци төрүүлж, ингэснээрээ дүрийг тодруулах давхар утга агуулсан байдаг тул тэдгээрийн нийгмийн үнэ цэнийг товойлгон харуулах үүднээс цааш цаашдын орчуулгад энэхүү чанар тусгалаа олох нь илүү зүй зохистой болно. “Байцаагч түшмэл”-ийн тухайд гэвэл Хлестаков “годройтуулах, шавдуулах”, Сквозник-Дмухановский

“нэв шувт үлээх”, Ляпкин-Тяпкин “хам хум, шалдар балдар”, Уховертов “чихдэх” гэх мэт илэрхий утга агуулсан нэрс уг зохиолд олон бий.

Дүгнэж хэлэхэд жүжгийн зохиолын орчуулгад баримталдаг гол гол зарчим буюу баатруудын яриа тайз болон драмын тогтолцоондоо зохицсон, найруулга ба хэлэхүйн чанараараа тухайн дүрд нийцтэй байх, өгүүлэмжийн утга санаа үзэгчдэд саадгүй түргэн ойлгогдож байх, соёлын нийтлэг болон ялгаатай талыг харгалзсан байх, төрөл зүйлийн хэлбэрээ зөв олсон байх зэрэг зарчмуудыг Э.Оюун орчуулгадаа баримталж байсан байна. Түүнээс гадна Э.Оюуны орчуулгын онцлог тал гэж үзэхээр бүтээлч хэлбэрийн элементүүдийг давамгайлж хэрэглэх, хэлсэтгэхүйн ялгааг бүдгэрүүлэх зорилгоор аль болох монголчлон найруулах, хэлц болон өвөрмөц хэллэгүүдийг шууд утгаар нь орчуулах зэрэг тал ажиглагдаж байна. Мөн эх хэлнийхээ яруу тансаг найруулгыг ашиглах, шүлэглэсэн зохиолын орчуулгад монгол яруу найргийн дэг жаягийг баримтлах, үг хэллэгт оновчтой утгыг нь тааруулж сонгох (шутить жизнью – *аминаасаа уйдах*; душой черствый – *сэтгэл эвэрших* г.м.) зэрэг нь Э.Оюуны орчуулгын давуу тал болж байна. Энэ үүднээс үзвэл орчин үеийн монголын театрын нэрт зүтгэлтэн, зохиолч, орчуулагч Э.Оюуны жүжгийн зохиолын орчуулгаар үлдээсэн өв үнэ цэнтэй, цаашид судлах, орчуулгын практикт харгалзаж хэрэглэх баялаг хэрэглэгдэхүүн болох бүрэн үндэстэй юм. Бас авах гээхийн ухаанаар хандаж сайжруулан орчуулах, сургамж авч суралцах зүйлс ч байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Резюме

В статье “Некоторый опыт Э.Оюун по переводу пьес”, посвященной 100-летию со дня рождения монгольского театрального деятеля, писателя и переводчика Э.Оюун, даётся обобщающий лингвистический анализ ее переводческих приёмов, в том числе, характерных для нее свободно-творческих склонностей в трансформации ментально- или культурно-маркированных элементов, присутствующих в драматических текстах. По убеждению автора, подобные склонности, по всей вероятности, были продиктованы задачами переводчика беспрепятственной передачи инокультурных языковых материалов монгольским зрителям. Объектом анализа являются переводы таких драматических текстов, как “Ревизор” Н.В.Гоголя, “Король Лир” У.Шекспира и “Иркутская история” А.Н.Арбузова.

Ном зүй

1. Ганхуяг Н. Монголын театрын нэвтэрхий толь. УБ., 2007
2. Гоголь Н.В. Байцаагч түшмэл. УБ., 1972
3. Лувсанжав Чой. Орос-монгол өвөрмөц хэллэгийн толь. УБ., 1970
4. Олицкая Д.А. Перевод драмы: специфика, проблемы, подходы. Вестник Томского гос. ун-та, 2012, №357
5. Оюун Э. Өгүүллэг – жүжиг. УБ., 1963
6. Пави, Патрис. Словарь театра. М., 1991
7. Шекспир У. Эмгэнэлт жүжгийн түүвэр. УБ., 2001
8. <http://www.allbest.ru/>